



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 12 сарын 28 өдөр

Дугаар 714

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах арга
хэмжээний тухай

Дотоод хэргийн их сургуулийн 2019 оны байдлаархи үндсэн хөрөнгийн хөдлөл, хөдөлгөөн, ашиглалт, хадгалалт, хамгаалалт, захиран зарцуулалт, эзэмшил газрын эрх зүйн үндэслэл, байр талбайн түрээсийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар Засгийн газрын 2001 оны 134 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгө түрээслүүлэх журам”-ыг зөрчин ХААН банкны АТМ машин эзэмшигчтэй гэрээ байгуулж, түрээсийн талбайн төлбөр тооцоогүй, бусад байгууллагаас 16.1 сая төгрөгийн тээврийн хэрэгслэлийг үнэ төлбөргүй шилжүүлж авахдаа Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх” журмыг мөрдөж ажиллаагүй зэрэг зөрчил, дутагдал илэрснийг тэмдэглээд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Дотоод хэргийн их сургуулийн 2019 оны үндсэн хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, захиран зарцуулалтад хийсэн шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. Дотоод хэргийн их сургуулийн захирал П.Батбаатарт санхүүгийн сахилга батыг хэвшүүлэн, дотоод хяналтыг сайжруулж дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг үүрэг болгосугай:

2.1. Шалгалтын тайланд дурдсан зөрчил, дутагдлыг арилгах төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж ажиллах;

2.2. Засгийн газрын 2001 оны 134 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгө түрээслүүлэх журам”, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн доод хязгаар, түрээсийн зарим төлбөрийн хэмжээг тогтоох заавар, улсын төсөвт төвлөрүүлэх орлогын хувь хэмжээг шинэчлэн батлах тухай 2020 оны 49 дүгээр тогтоолыг хэрэгжүүлж ажиллах;

2.3. ХААН банкны АТМ машин эзэмшигчтэй төрийн өмчийн талбайн түрээсийн гэрээг холбогдох журмын дагуу байгуулах;

2.4. Сургуулийн эзэмшил газар дээр зөвшөөрөлгүй байралсан ТҮЦ-ийг буулгаж, өөрийн болон төрийн эзэмшил газрыг чөлөөлүүлж авах. Шаардлагатай тохиолдолд хууль хяналтын байгууллагад хандах;

2.5. Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах төлөвлөгөөний биелэлтийг 2021 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн Хяналт шалгалтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГА


ТӨРИЙН ӨМЧИЙН ХЯНАЛТ
ШАЛГАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Ц.ТҮВШИНЗАЯА



Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 7.7/дугаар тогтоолын хавсралт



Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал,
түүнийг арилгах арга хэмжээний жагсаалт

№	Зөрчил, дутагдлын утга	Хариуцах эзэн	Дүн /мян.төгрөг/	Зөрчил дутагдлыг арилгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ
1	Бусдаас үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй авахдаа эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авч данс бүртгэлд тусгаагүй	Захирал П.Батбаатар Ерөнхий ня-бо Ч.Лхагважав	16,100.0	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх" журмыг
	Дүн		16,100.0	
2	Сургуулийн байр талбайд байршуулсан ХААН банкны АТМ машин эзэмшигчтэй гэрээ байгуулж түрээсийн төлбөр аваагүй			Засгийн газрын 2001 оны 134 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгө түрээслүүлэх журам", Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын "Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн доод хязгаар, түрээсийн зарим төлбөрийн хэмжээг тогтоох заавар, улсын төсөвт төвлөрүүлэх орлогын хувь хэмжээг шинэчлэн батлах тухай 2020 оны 49 дүгээр тогтоолыг хэрэгжүүлж ажиллах